

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	7
2.9.	Аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11.	Шилэн дансны мэдээлэл	8
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2	Аудит хийсэн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	15



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.25 № 06/575
танай _____-ны № _____-т

「 Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Хэрэмт цамхаг УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус УТҮГ-ын захирал, хурандаа Т.Эрдэнэжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан,тодруулгад аудит хийлээ.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан,тодруулгад Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 01–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-ний өдөр эцэслэн баталгаажуулж, “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын захиралд хүргүүлэхээр төлөвлөн, “Төгс нягт гурав аудит” ХХК-ий захирал Д.Цэнд хянан удирдаж, чанарын хяналтын менежер З.Тунгалаг, аудитор Д.Эрдэнэтуяа, аудиторын туслах С,Баярсайхан нар хэрэгжүүлэв.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/96 тоот албан бичгээр хуулийн хугацаанд “Төгс нягт гурав аудит” ХХК-д ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу үе шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо. Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын талаархи ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын эрхэм зорилго нь салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх, үйлдвэрт ажиллах хоригдолд мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадал олгох, хөдөлмөрөөр дамжуулан хоригдлыг нийгэмшүүлэх, дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чанартай стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдийг хангахад оршино гэж тодорхойлон ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл: Тус байгууллага нь 2007 оны 3 дугаар сарын 1–нд Татварын Ерөнхий Газрын Улсын бүртгэлийн албанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дэргэдэх “Хэрэмт цамхаг” УТҮГ нэрээр 5120284 тоот регистрийн дугаартай бүртгүүлж барилгын материал үйлдвэрлэл, оёдлын үйлдвэрлэл гэсэн үйл ажиллагааны чиглэлээр бүртгүүлж дор дурьдсан үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Үүнд:

1. Хөнгөн блокын үйлдвэрийг дөрвөн улирлын туршид бүрэн хүчин чадлаараа ажиллах нөхцөл бололцоог ханган ажиллах;
2. Хөнгөн блок үйлдвэрлэлийн тохирлын гэрчилгээ авахаар бүтээгдэхүүний чанар стандартыг мөрдүүлэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн ажиллах;
3. Хөнгөн блокны үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг бэлтгэж ханган ажиллах;
4. Шаардлагатай түүхий эд материалын нөөц бүрдүүлэн ажиллах;
5. Хөнгөн блокны үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жигд аюулгүй ажиллагааг тасралтгүй бүрэн хангаж ажиллах;
6. Үйлдвэрлэж байгаа вакум цонх, хаалга, хаалтыг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн системийн хэмжээнд болон зах зээлд нийлүүлэх;
7. Вакум цонхны үндсэн түүхий эд болон туслах материалыг хямд өртгөөр зах зээлээс татан авч чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
8. Үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, борлуулалтын төлөвлөгөөг ханган ажиллах;
9. Үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг ханган ажиллах;

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын удирдлага Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС-ын хүрээнд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Шүүхийн Шийдвэр гүйцэтгэх тухай хууль

- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын тухай хууль.
- Барилгын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус байгууллага санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “unicus” санхүүгийн программаар гаргаж дээд шатны байгууллагад нэгтгүүлсэн байна.

Системийн хэмжээнд мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх аргачлалыг тусгаж өгөөгүй байна.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Хэрэмт цамхаг” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож түүний 1 хувиар, материаллаг байдлын түвшинг тооцов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аж ахуй нэгж байгууллагад өртөг зардлыг голчлон авч үздэгтэй холбоотой юм.

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын 2018 оны нийт зардал 1,593.7 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 15.9 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Төлөвлөсний дагуу эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 10 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 8 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан. Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(сая.төг)
				Тайлбар
1	Зөвлөмж	2	0.0	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараахь заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Цаашид энэ байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг төсөв, үйлдвэрийн газар гэж ялгалгүйгээр нэгдсэн аудит хийх нь зүйтэй.

2.9. Аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагч болон газрын даргын баталсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах ажил гүйлгээнүүд гарсан байна.

1.Худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 874.0 сая төгрөгийн өртөгтэй Өвөрхангай аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхий газрын барилгын ажлыг тус байгууллагын дансаар дамжуулан санхүүжүүлсэн.

2.Тус байгууллагын Голомт банкин дахь 1102932549 тоот дансанд өөрийн үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй дараах мөнгөнүүдийг байршуулсан байна. Үүнд:

- Төв аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт “Нэг цонхны үйлчилгээ бүхий албан контор,цагдан хорих байр” барих 245,2 сая төгрөг
- Хорих 407 р ангид “Хаалттай дэглэмийн хоригдлын байр” барихад 731.8 сая төгрөг

- Сургалт хийх зорилгоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ерөнхийн газрын төсөвт тусгагдсан гэх 318.0 сая төгрөг

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд барилгын материал үйлдвэрлэлийн үйл ажиллагааны орлого 1,663.4 сая төгрөг, бусад орлогоос 58.1 сая төгрөг нийт 1,721.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, бүтээгдэхүүний өөрийн өртөг 1,498.5 сая төгрөг, бусад зардал 111.0 сая төгрөг, нийт 1,609.5 сая төгрөгийн зардал гаргаж, 99.1 сая төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласан байна.

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын эргэлтийн бус хөрөнгө болох барилгын дахин үнэлгээг хийж хөрөнгө 539.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн хараат бус мэргэшсэн үнэлгээчин Б.Эрдэнэбаатар нь үнэлгээний тайланг нягтлан шалгах ажлыг гүйцэтгэж "Дахин үнэлгээг заавар, аргачлалын дагуу үнэн зөв хийсэн байна" гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

"Хэрэмт цамхаг" УТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн дагуу "Хэрэмт цамхаг" УТҮГ нь орлого, зардал, бусад холбогдох мэдээллийн талаар [info.shilendans.gov.mn/ login](http://info.shilendans.gov.mn/) хуудсанд оруулсан байна. 2018 оны 11 дүгээр сард Үндэсний аудитын газраас хийгдсэн шалгалтаар зөрчил илрээгүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 /нэг/ зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Хэрэмт цамхаг" УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Хэрэмт цамхаг" УТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Илрүүлэлт

1.1 Бараа материалын тайланг гаргахдаа бүтээгдэхүүний үнэ өртгийг буруу тайлагнасан байна.

1.2 Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх ;

1.3 Зөвлөмж

Нягтлан бодогч, эдийн засагч, нярав нар үйлдвэрлэсэн бэлэн бүтээгдэхүүний тоо өртгийг хөдлөл бүрээр нь үнэн зөв бүртгэлд тусгаж хэвших, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 20 дугаар зүйлийн 20.2.2 дох заалтуудыг мөрдөж ажиллах

2. Илрүүлэлт

Системийн хэмжээнд мөрдөгдөж байгаа НБББББ-т тус байгууллагын тус байгууллагын онцлог буюу аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүртгэлийг хөтлөх аргачлал тусгаагүйгээс, бүтээгдэхүүний өртөгийг өөр өөрөөр тооцож, бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

2.1 Эрсдэл

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх ;

2.2 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж, бодлого арга зүйг тодорхой болгон, бараа материалын өртгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 20 дугаар зүйлийн 20.2.2 дох заалтуудыг мөрдөж ажиллах;

2.3 Байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнуудын хариу

Илрүүлэлтийн талаар хариу тайлбар ирүүлээгүй болно.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг гаргаж Үндэсний аудитын газарт, Төгс нягт гурав аудит ХХК-д 2019 оны 6 дугаар сарын 15 -ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2017 оны 12 сарын 31	2018 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.01	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,153,769,698.71	1,632,357,321.89
1.1.02	Дансны авлага	91,665,964.40	70,387,414.40
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	56,519.00	6,493.84
1.1.04	Бусад авлага	1,084,000.00	500,000.00
1.1.06	Бараа материал	31,248,829.83	112,655,883.55
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	152,475,000.00	88,306,818.18
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,430,300,011.94	1,904,213,931.86
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.01	Үндсэн хөрөнгө	764,862,039.94	1,231,023,914.24
1.2.02	Биет бус хөрөнгө	998,525.64	626,602.56
1.2.10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	765,860,565.58	1,231,650,516.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,196,160,577.52	3,135,864,448.66
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.2.01	Дансны өглөг	10,000,000.00	5,000,000.00
2.1.1.03	Татварын Өр	32,319,638.39	10,820,627.96
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	1,167,916,457.04	1,495,207,749.95
2.1.1.13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,210,236,095.43	1,511,028,377.91
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,210,236,095.43	1,511,028,377.91
2.3.01	Өмч:-төрийн	161,096,688.93	161,096,688.93
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,297,769,167.27	1,837,618,788.49
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(472,941,374.11)	(373,879,406.67)
2.3.09.1	Тайлант үеийн үр дүн		99,061,967.44
2.3.09.2	Өмнөх үеийн үр дүн	(472,941,374.11)	(472,941,374.11)
2.3.11	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	985,924,482.09	1,624,836,070.75
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,196,160,577.52	3,135,864,448.66

4.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (цэвэр)	587,756,427.29	1,663,339,949.68
2	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	490,802,688.01	1,498,461,035.21
3	НИЙТ АШИГ (алдагдал)	96,953,739.28	164,878,914.47
5	Хүүгийн орлого		41,525,559.88
8	Бусад орлого	557,628.07	16,603,528.94
8.1	ОРЛОГЫН ДҮН	557,628.07	58,129,088.82
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,888,595.31	2,564,545.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	127,248,603.83	92,739,780.23
12.1	ЗАРДЛЫН ДҮН	130,137,199.14	95,304,325.69
17	Бусад ашиг (алдагдал)	(81,996,364.39)	(15,687,576.22)
17.1	ОЛЗ, ГАРЗЫН ДҮН	(81,996,364.39)	(15,687,576.22)
18	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ / алдагдал /	(114,622,196.18)	112,016,101.38
19	Орлогын татварын зардал		12,954,133.94
20	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ / алдагдал /	(114,622,196.18)	99,061,967.44
22	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ /АЛДАГДАЛ /	(114,622,196.18)	99,061,967.44
24	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	-	-

4.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2016 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	161,096,688.93	1,297,769,167.27	-358,319,177.93	1,100,546,678.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө , алдааны залруулга				0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-114,622,196.18	-114,622,196.18
2017 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	161,096,688.93	1,297,769,167.27	-472,941,374.11	985,924,482.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө , алдааны залруулга				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			99,061,967.44	99,061,967.44
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		539,849,621.22		539,849,621.22
2018 ОНЫ 12-Р САРЫН 31-ЭЭРХ ҮЛДЭГДЭЛ	161,096,688.93	1,837,618,788.49	-373,879,406.67	1,624,836,070.75

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	1,608,997,633.14	2,128,395,660.73
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	428,189,950.00	442,155,500.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө /ТӨҮГ/		56,519.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,180,807,683.14	1,686,183,641.73
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	355,589,849.10	1,611,333,597.43
1.2.1	Ажиллагчдад төлсөн	106,729,162.20	121,591,387.90
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,135,283.48	2,559,382.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	182,170,782.34	1,280,040,599.16
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	9,582,196.21	16,526,212.61
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	33,054,716.66	109,327,385.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	16,533,923.21	57,330,093.09
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	-	540,490.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	5,383,785.00	23,418,047.00
1.3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	1,253,407,784.04	517,062,063.30
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)		41,525,559.85
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	41,525,559.88
2.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)		
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		41,525,559.88
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)		
3.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	100,000,000.00	80,000,000.00
3.2.5	Бусад	100,000,000.00	80,000,000.00
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(100,000,000.00)	(80,000,000.00)
4	БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,153,407,784.04	478,587,623.18
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	361,914.67	1,153,769,698.71
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,153,769,698.71	1,632,357,321.89

5 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.12.31	Аудитын нэр:	Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн	Аудитын код:	САГ-2019/39/СТА-ТӨҮГ
---------------	-------------------	---------------------	---	---------------------	-----------------------------

Шалгагдсан байгууллагын нэр:	Хэрэмт цамхаг УТҮГ	Сая.төг
-------------------------------------	---------------------------	----------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл		
			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	Нэр	Албан тушаал
A	3	4	5	8	9
2	Бараа материалын тайланг гаргахдаа 6.7.8 сарын тайлангийн үнэ өртгийг буруу тайлагнасан		зөвлөмж	Захирал	Т.Эрдэнэжаргал
				Няглан бодогч	Д.Гэгээнцэцэг
3	Системийн хэмжээнд мөрдөгдөж байгаа НБББББ-т тус байгууллагын бүртгэлийг хөтлөх аргачлал тусгагдаагүй, бараа материалын өртгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 20 дугаар зүйлийн 20.2.2 дох заалтуудыг баримтлаагүй тайлагнасан		зөвлөмж	Захирал	Т.Эрдэнэжаргал
				Няглан бодогч	Д.Гэгээнцэцэг
	Дүн	0.0			